



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/684

Булган сум

Лаборант, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны VI дугаар хуралдааны “Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай” VI/32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээг өөрийн аймагт хийх чадавхыг бэхжүүлэх, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын мэргэжилтнүүдэд чанарын гадаад хяналт хийх мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх зорилгоор зохион байгуулах сургалтын удирдамж, хөтөлбөрийг 1 дүгээр, сургалтад зарцуулагдах зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Лаборант, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг үр дүнтэй, чанартай зохион байгуулж, лабораторийн чанарын хяналтыг сайжруулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг)-т даалгасугай.

3. Дээрх сургалтад зарцуулагдах 2,711,840 (хоёр сая долоон зуун арван нэгэн мянга найман зуун дөчин) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



0325010955

Сугар Ажир 2025 өдөр бүр Дуг 2025/Захирамж

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 28-ны/ний өдрийн
А/684 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



“Эрүүл мэндийн байгууллагуудын лабораторийн шинжилгээний гүйцэтгэлд чанарын гадаад үнэлгээ зохион байгуулах” сургалтын удирдамж

Үндэслэл:

Монгол Улсад эмнэлзүйн лабораторийн шинжилгээний Чанарын гадаад үнэлгээг гематологи, биохими, цусаар дамжих халдвар, сүрьеэ, иммунологи, нян судлал, бүлэгнэлт, цусны тохирооны чиглэлээр Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/485 дугаар тушаалд туссаны дагуу тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн лавлагаа лабораториудын мэргэшсэн багууд зохион байгуулж байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг чадавхжуулах үйл ажиллагааны хүрээнд аймаг, орон нутгийн хэмжээнд Чанарын гадаад үнэлгээг эхлүүлэх, цаашид бие даан зохион байгуулахад орон нутгийн эмч, мэргэжилтнийг сургаж дадлагажуулах, чадавхжуулах, чанарын гадаад үнэлгээний үйл ажиллагааг бэхжүүлэхэд Чанарын гадаад үнэлгээний мэргэжлийн баг зөвлөгөө өгч ажиллаж байна.

Зорилго:

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээг өөрийн аймагт зохион байгуулах үйл ажиллагааг бэхжүүлэх, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын мэргэжилтнүүд Чанарын гадаад хяналт хийх мэдлэг, ур чадвар нэгдсэн ойлголттой болно.

Зохион байгуулагч:

- 1.Аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтэс
- 2.Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Лабораторийн тасаг
- 3.Чанарын гадаад үнэлгээний мэргэжлийн зөвлөх баг

Сургалт зохион байгуулах өдөр:

2025 оны 11 дүгээр сарын 06-07-ны өдрүүдэд

Сургалт зохион байгуулах газар:

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн тасаг, сургалтын танхимд

Оролцогч:

Аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторийн тасгийн их эмч, лаборант, эмнэлгийн мэргэжилтнүүд, өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн лаборант нар

Сургалтын үр дүн:

1.Аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн тасгийн их эмч, лаборант, эмнэлгийн мэргэжилтнүүд, өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн лаборант нар Чанарын гадаад хяналт хийх мэдлэг, ур чадвар нэгдсэн ойлголттой болно.

2.Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвийг гадаад хяналтын шинжилгээнд хамруулан гэрчилгээ олгоно.

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 28-ны ний өдрийн
А/684 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
ГҮЙЦЭТГЭЛД ЧАНАРЫН ГАДААД ҮНЭЛГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ”
СУРГАЛТЫН ТӨСӨВ**

д/д	Шаардлагатай зардал	Хэмжих нэгж	Тоо	Үнэ (төгрөг)	
				Нэг бүр	Нийт
1	2	3	4	5	6
1	Сургагч багш нарын Улаанбаатар-Эрдэнэт ирэх, буцах замын зардал	Ш	8	54500	436,000
2	Эрдэнэт-Булган явах замын зардал /ДТ-120км/	Л	26.4	3100	81840
3	Сургагч багшийн ажлын хөлс	Ш	4	125,000	500,000
4	Сургагч багш нарын зочид буудал	Хүн.өдөр	4 хүн 2 хоног	75,000	600,000
5	Сургагч багш нарын хоолны зардал	Ш	24	20,000	480,000
6	Сургалтын цайн завсарлагааны зардал	Ш	30	8000	240,000
7	Сумаас ирсэн лаборантуудын өдрийн хоолны зардал	Ш	17	22000	374,000
	Нийт				2,711,840